



Most Money

ТӨЛБӨРИЙН НЭГДСЭН ҮЙЛЧИЛГЭЭ



Нэг. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ

1. Most Money гэж юу вэ? 4
2. Most Money-ийг хэрхэн ашиглах вэ? 5

Хоёр. МЕНЮ СУУЛГАХ

1. Most Money меню 6
2. Меню суулгах алхам 7

Гурав. ГАР УТСААР ГҮЙЛГЭЭ ХИЙХ

1. Мөнгөн шилжүүлэг гүйлгээ хийх 8
 - Банкны данс руу 8
 - Бусдын утас руу 10
 - Өөрийн данс хооронд 11
2. Худалдан авалт гүйлгээ хийх 13
3. Билл төлбөр гүйлгээ хийх 14
4. Элдэв төлбөр гүйлгээ хийх 17

5. ТАН код авах 18
6. АТМ дээрээс бэлэн мөнгө авах 19
7. Лавлагаа авах
 - Үлдэгдэл шалгах 20
 - Сүүлийн гүйлгээ лавлах 21
8. Шинэчлэх
 - ПИН код солих 22
 - Үндсэн данс солих 23
 - Меню шинэчлэх 24
 - Тохиргоо 25

Дөрөв. ВЭБЭЭР ГҮЙЛГЭЭ ХИЙХ 26

Тав. АСУУЛТ & ХАРИУЛТ 27

Зураа. ТУСЛАМЖ 33

Эрхэм Танаа,

Most Money үйлчилгээний хэрэглэгч болсонд баярлалаа.

MOST MONEY ГЭЖ ЮУ ВЭ?

Банкны дансуудаа (карт, харилцах, хугацаатай & хугацаагүй хадгаламж) гар утастайгаа холбуулснаар гар утас болон вэбээр хүссэн үедээ (24/7) дансаа удирдан зарцуулах, гүйлгээ хийх боломжийг Most Money Танд олгож байна.



Төлбөрийн нэгдсэн үйлчилгээ:

Зөвхөн нэг банк, операторын үйлчилгээ бус олон банк, оператор, бизнесийн болон төрийн байгууллагуудыг өөртөө нэгтгэх төлбөрийн нэгдсэн үйлчилгээ.



Бодит үнэ цэнэтэй үйлчилгээ:

Байгаа газраасаа гар утас, вэб ашиглан банкны болон төлбөрийн үйлчилгээг авах учир цаг хугацаа, замын зардлыг бодитоор хэмнэх үйлчилгээ.



HiTech, Cool үйлчилгээ:

ОУ-ын банк, санхүүгийн салбарын сүүлийн үеийн дэвшилтэт шийдлүүдийг өөртөө агуулж, хувь хүний санхүүгийн нууцлал, гүйлгээний аюулгүй байдлыг хангасан жинхэнэ “cool” үйлчилгээ.



Хэрэглэхэд хялбар, энгийн үйлчилгээ:

Гар утас болон вэбийн цэс нь хэрэглэхэд хялбар, энгийн ойлгомжтой бүтэцтэй бөгөөд төлбөрийн үйлчилгээний хөгжлийг нэг шат ахиулсан үйлчилгээ.

MOST MONEY-Д ЯМАР ҮЙЛЧИЛГЭЭНҮҮД БАЙДАГ ВЭ?



Мөнгөн шилжүүлэг

Та уг үйлчилгээг ашиглан дурын банкны данс руу, Most Money-н хэрэглэгчийн гар утас руу мөн өөрийн данс хооронд хормын төдөйд банк дотор ч банк хооронд ч мөнгө шилжүүлж, хүлээн авна.



Худалдан авалт

Та Most Money-н таних тэмдэгтэй худалдаа үйлчилгээний газруудаас гар утас, вэб, картын ПОС-оор шууд болон зайнаас худалдан авалт хийх боломжтой.



Билл төлбөр

Та дараа төлбөрт орон сууц, цахилгаан, СӨХ, гар утас, суурин утас, интернэт зэрэг үйлчилгээний төлбөрийг банк руу явалгүйгээр хормын төдөйд төлөх боломжтой.



Элдэв төлбөр

Тоон KaTB, IP суурин утас, интернэт, ОУ-ын яриа зэрэг урьдчилсан төлбөрт үйлчилгээний төлбөрөө цаг хугацаа алдалгүйгээр төлөх боломжтой.



Бэлэн зарлага, орлого

Та картаа мартсан ч, хаясан ч, залгиулсан ч АТМ-ээс гар утсаараа мөнгө авч, Most Money-д нэгдсэн дурын банкин дээр очин данснаасаа мөнгө авах, орлого хийх боломжтой.



Лавлах

Та дансны үлдэгдлээ шалгах, сүүлийн хийсэн гүйлгээгээ лавлах боломжтой. Мөн вебээс дурын хугацааны интервалаар дансны хуулгаа харах боломжтой.

1. MOST MONEY МЕНЮ

Хэрэглэгч Таны гар утасны чадамжнаас хамааран бид Танд 4 төрлийн Most Money менюг санал болгож байна:

	 Энгийн меню	 Интернет меню	 Android меню	 iPhone меню
Гар утас	Бүх төрлийн гар утсанд	Интернэт дэмждэг гар утсанд	Android системтэй гар утсанд	iOS үйлдлийн системтэй iPhone-ны утсанд
Мэдэгдэл ирэх байдал	Мессежээр мэдэгдэл ирнэ.	Гар утасны дэлгэц дээр харагдана.	Гар утасны дэлгэц дээр харагдана.	Гар утасны дэлгэц дээр харагдана.
Меню шинэчлэх	Менюнд нэмэлт өөрчлөлт орох бүрт шинэчлэнэ.	Меню дахин татаж авна.	Меню дахин татаж авна.	Меню дахин татаж авна.
ПИН код ашиглах	Гүйлгээ хийх бүр ПИН код шаардана.	Анх меню рүү нэвтрэхэд л шаардана.	Анх меню рүү нэвтрэхэд л шаардана.	Анх меню рүү нэвтрэхэд л шаардана.
Давхар ашиглах боломж	СИМ дээр меню байрших учир тухайн утасны эзэн л ашиглана.	Менюг хэдэн ч хэрэглэгч ашиглах боломжтой.	Менюг хэдэн ч хэрэглэгч ашиглах боломжтой.	Менюг хэдэн ч хэрэглэгч ашиглах боломжтой.

2. МЕНЮ СУУЛГАХ АЛХАМ:

	 Энгийн меню	 Интернет меню	 Android меню	 iPhone меню
1	579 - On гэж илгээнэ	Вэбээс http://menu.mostmoney.mn/ гэж орно	Google Play-ээс Most Money нэрээр хайлт хийнэ	App store-с Most Money нэрээр хайлт хийнэ
2	Mobicom доторх Most Money меню рүү орон "Shinechlex" үйлдлийг хийнэ.	Customer Applet-ийг татаж суулгана.	Татаж суулгана.	Татаж суулгана.
3	Меню Mobicom дотор суух бөгөөд меню рүү анх ороход хэл сонгох үйлдэл хийнэ.	Меню Games эсвэл Application дотор сууна.	Меню Application байдлаар харагдана.	Меню Application байдлаар харагдана.

Гурав. ГАР УТСААР ГҮЙЛГЭЭ ХИЙХ

МӨНГӨН ШИЛЖҮҮЛЭГ ГҮЙЛГЭЭ ХИЙХ


1. Банкны данс руу

Та уг гүйлгээгээр дурын банкны харилцагчийн данс руу мөнгө шилжүүлэх боломжтой. Хүлээн авагч нь заавал Most Money үйлчилгээний хэрэглэгч байх албагүй. Банк дотроо бол тухайн агшиндаа таны мөнгө хүлээн авагчийн дансанд орно, харин банк хооронд гүйлгээ хийж байгаа бол одоо банкны системд мөрдөгдөж буй банк хоорондын гүйлгээний дагуу ажлын 2 цагийн дотор гүйлгээ орно.


Банкны данс руу шилжүүлэг хийх заавар:




1. Мөнгөн шилжүүлэг үйлчилгээг сонгоно.




2. Банкны данс руу дэд менюг сонгоно.
3. ПИН кодоо оруулна.




4. Холбуулсан дансуудаас шилжүүлэх дансаа сонгоно.




5. Хүлээн авах банкаа сонгоно.
6. Хүлээн авагчийн дансны дугаарыг оруулна.



7. Хүлээн авагчийн дансны валютыг сонгоно.
8. Данс эзэмшигчийн нэрийг бичнэ.
9. Гүйлгээний дүнгээ оруулна.




10. Гүйлгээний валютыг сонгоно.
11. Гүйлгээний утга оруулна. Заавал оруулах шаардлагагүй.
12. Оруулсан мэдээлээ шалгаж баталгаажуулан "OK" товчийг дарна.
13. Гүйлгээ амжилттай эсвэл амжилтгүй болсон мэдэгдэл хэрэглэгчийн тохируулсан мэдэгдэл хүлээн авах сувгаар ирнэ.




2. Бусдын утас руу

Та уг гүйлгээгээр Most Money үйлчилгээний хэрэглэгчийн гар утасны дугаар руу мөнгө шилжүүлэх боломжтой.


Бусдын утас руу мөнгөн шилжүүлэг хийх заавар:




1. Мөнгөн шилжүүлэг үйлчилгээг сонгоно.



2. Бусдын утас руу дэд менюг сонгоно.
3. ПИН кодоо оруулна.



4. Холбуулсан дансуудаас шилжүүлэг хийх дансаа сонгоно.
5. Хүлээн авагчийн утасны дугаарыг оруулна.
6. Гүйлгээний дүнгээ оруулна.



7. Гүйлгээний валютыг сонгоно.
8. Гүйлгээний утга оруулна. *Заавал оруулах шаардлагагүй.*
9. Оруулсан мэдээлээ шалгаж баталгаажуулан “OK” товчийг дарна.
10. Гүйлгээ амжилттай эсвэл амжилтгүй болсон мэдэгдэл хэрэглэгчийн тохируулсан мэдэгдэл хүлээн авах сувгаар ирнэ.




Хүлээн авагчийн утасны дугаар Most Money үйлчилгээнд бүртгүүлсэн байх шаардлагатайг анхаарна уу.


3. Өөрийн данс хооронд

Энэхүү гүйлгээгээр Most Money үйлчилгээнд холбуулсан өөрийн данс хооронд мөнгөн шилжүүлэг хийх боломжтой юм. Энэхүү цэс нь Танд өөрийн данс хооронд гүйлгээ хийхэд дансны дугаар бичих үйлдлийг хөнгөвчилж өгч байгаагаараа давуу талтай юм.


Өөрийн данс хооронд мөнгөн шилжүүлэг хийх заавар:




1. Мөнгөн шилжүүлэг үйлчилгээг сонгоно.




2. Өөрийн данс хооронд дэд менюг сонгоно.
3. ПИН кодоо оруулна.



4. Өөрийн шилжүүлэг хийх дансаа сонгоно.



5. Өөрийн хүлээн авах дансаа сонгоно.
6. Гүйлгээний дүнгээ оруулна.




7. Гүйлгээний валютыг сонгоно.
8. Гүйлгээний утга оруулна. *Заавал оруулах шаардлагагүй.*
9. Оруулсан мэдээлээ шалгаж баталгаажуулан "ОК" товчийг дарна.
10. Гүйлгээ амжилттай эсвэл амжилтгүй болсон мэдэгдэл хэрэглэгчийн тохируулсан мэдэгдэл хүлээн авах сувгаар ирнэ.




ХУДАЛДАН АВАЛТ ГҮЙЛГЭЭ ХИЙХ

Та уг гүйлгээгээр Most Money үйлчилгээний таних тэмдэг бүхий худалдаа, үйлчилгээний байгууллагуудаар худалдан авалт хийх боломжтой.


Худалдан авалт гүйлгээ хийх заавар:



1. Худалдан авалт гүйлгээг сонгоно.
2. ПИН кодоо оруулна.



3. Холбуулсан дансуудаас шилжүүлэх дансаа сонгоно.
4. Худалдагчийн утасны дугаарыг оруулна.
5. Гүйлгээний дүнгээ оруулна.



6. Гүйлгээний валютыг сонгоно
7. Гүйлгээний утга оруулна. *Заавал оруулах шаардлагагүй.*
8. Оруулсан мэдээллээ шалгаж баталгаажуулан "ОК" товчийг дарна.
9. Гүйлгээ амжилттай эсвэл амжилтгүй болсон мэдэгдэл хэрэглэгчийн тохируулсан мэдэгдэл хүлээн авах сүвгаар ирнэ.



Худалдан авалт гүйлгээг зөвхөн төгрөгөөр хийнэ.



БИЛ ТӨЛБӨР


Та уг гүйлгээгээр дараа төлбөрт үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын дурын хэрэглэгчийн биллийг төлөх боломжтой. Дараа төлбөрт үйлчилгээ үзүүлэгч гэдэг нь : Цахилгаан, орон сууц, СӨХ, интернэт гэх мэт үйлчилгээгээ үзүүлсний дараа төлбөрөө нэхэмжилдэг байгууллагуудыг хэлнэ.

Төлбөрөө шууд төлөхөөс гадна хэдэн төгрөгийн билл ирснийг шалгаад төлөх боломжтой. Та хэрэглэгчийн вэбээрээ орж шууд болон шалгаж төлөх биллүүдийн жагсаалтаа нэмэж, хасаж, засварлаж болно.


Билл Төлбөр гүйлгээ хийх заавар:

1. Билл төлөх:


Төлбөрийн дүн, Хэрэглэгчийн дугаараа оруулаад л шууд төлбөрөө төлж болох гүйлгээ. Жишээ нь Мобикомын утасны дугаараа, төлөх дүнтэйгээ оруулаад төлөх боломжтой.




1. Билл төлбөр үйлчилгээг сонгоно.
2. ПИН кодоо оруулна.



3. Билл төлөх цэсийг сонгоно.



4. Биллрийн жагсаалтаас төлбөр төлөх биллэрээ сонгоно*



5. Холбуулсан дансуудаасаа шилжүүлэх дансаа сонгоно.

6. Төлбөрийг нь төлөх хэрэглэгчийн дугаараа оруулна.
7. Төлөх дүнгээ оруулна
8. Гүйлгээний утга оруулна. *Заавал оруулах шаардлагагүй.*
9. Оруулсан мэдээлээ шалгаж баталгаажуулан "OK" товчийг дарна.
10. Гүйлгээ амжилттай эсвэл амжилтгүй болсон мэдэгдэл хэрэглэгчийн тохируулсан мэдэгдэл хүлээн авах /Бил төлбөрийн гүйлгээний хувьд и-мэйл мэдэгдлийг давхар илгээнэ/




Хэрэглэгчийн дугаар, төлбөрийн дүнгээ сайтар нягтлаад төлбөрөө төлнө үү. Хэрэглэгчийн дугаар, төлбөрийн дүнгээ мэдэхгүй бол дараа төлбөрт үйлчилгээ үзүүлэгч байгууллагаасаа лавлана уу.




2. Бүртгэлтэй бил төлөх:


Бүртгэл хийсний дараа төлбөрөө шалгаад төлөх боломжтой гүйлгээ. Жишээ нь: Байрны мөнгөө хэд гарсныг шалгаад төлөх боломжтой.




1. Бил төлбөр үйлчилгээг сонгоно.
2. ПИН кодоо оруулна.



4. Биллериин жагсаалтаас төлбөр төлөх биллэрээ сонгоно.



3. Бүртгэлтэй бил төлөх цэсийг сонгоно.



5. Шилжүүлэх дансаа сонгоно.

6. Дэлгэцэн дээр төлөх биллийн мэдээллийг харуулна.
7. Биллийн мэдээллийг шалгаад "OK" товчийг дарж цааш үргэлжлүүлнэ.
8. Биллийг бүтнээр нь төлөх бол "OK", хэсэгчилж төлөх бол "back" товчийг дарна.
9. Биллийг хэсэгчилж төлөх бол "Tiim", үгүй бол "Ugui" товчийг дарна.
10. Хэсэгчилж төлөх дүнгээ оруулаад "OK" товчийг дарна.
11. Оруулсан мэдээллээ шалгаж баталгаажуулан "OK" товчийг дарна.
12. Гүйлгээ амжилттай эсвэл амжилтгүй болсон мэдэгдэл хэрэглэгчийн тохируулсан мэдэгдэл хүлээн авах сүвгаар ирнэ.

/Бил төлбөрийн гүйлгээний хувьд и-мэйл мэдэгдлийг давхар илгээдэг/




ЭЛДЭВ ТӨЛБӨР ГҮЙЛГЭЭ ХИЙХ


Та уг гүйлгээгээр урьдчилсан төлбөрт үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын бараа, үйлчилгээг худалдан авах, төлбөрийг төлөх боломжтой.

Урьдчилсан төлбөрт үйлчилгээ үзүүлэгч гэдэг нь : ОУ-ын ярианы карт, интернэт, кабелийн телевиз гэх мэт үйлчилгээг үзүүлэхийнхээ өмнө урьдчилан төлбөрөө хураан авдаг байгууллагуудыг хэлнэ.

Элдэв төлбөр гүйлгээ хийх заавар:



1. Eldev tolbor үйлчилгээг сонгоно.
2. ПИН кодоо оруулна.



3. Шилжүүлэх дансаа сонгоно.
4. Бүтээгдэхүүний код оруулна.
5. Хүлээн авах хэрэглэгчийн дугаарыг оруулна.
6. Гүйлгээний утга оруулна. Заавал оруулах шаардлагагүй.
7. Оруулсан мэдээлээ шалгаж баталгаажуулан "ОК" товчийг дарна.
8. Гүйлгээ амжилттай эсвэл амжилтгүй болсон мэдэгдэл хэрэглэгчийн тохируулсан мэдэгдэл хүлээн авах сувгаар ирнэ.




Та хэрэглэгчийн дугаараа мэдэхгүй бол үйлчилгээ үзүүлэгч байгууллагаасаа лавлана уу. Харин бүтээгдэхүүний кодыг лавлах бол Most Money үйлчилгээний 33-57-57 дугаарт хандана уу.


ТАН КОД АВАХ

ТАН код гэдэг нь хэрэглэгчийн ПИН кодны нууцлалыг хангах үүднээс гар утас, вэб дээрээс ПИН кодоо ашиглан авах, нэг удаа ашиглах, ПИН кодыг орлох нууцлал юм. Өөрөөр хэлбэл АТМ дээрээс бэлэн мөнгө авах, худалдаа үйлчилгээний газраас бараа үйлчилгээ худалдан авахад кассын ПОС дээр хэрэглэгч ПИН кодоо оруулуулахаас сэргийлэн нэг удаа ашиглах ТАН кодыг ашиглана.

ТАН код авах заавар:



1. ТАН код авах үйлчилгээг сонгоно.
2. ПИН кодоо оруулна.



3. ТАН код нь 6 оронтой тоо байна



ТАН кодны хүчинтэй байх хугацаа 5 минут тул Та уг хугацаанд багтааж гүйлгээгээ хийнэ үү. Нэг ашигласан ТАН кодыг дахин ашиглах боломжгүй.



АТМ ДЭЭРЭЭС БЭЛЭН МӨНГӨ АВАХ

Most Money үйлчилгээнд нэгдсэн банкны дурын АТМ дээрээс гар утсаа ашиглан бэлэн мөнгө авах боломжтой.

АТМ дээрээс бэлэн мөнгө авах заавар:

"MOST MONEY"
БЭЛЭН МӨНГӨ АВАХ

1. АТМ-ын дэлгэцний зүүн талд байрлах "MOST MONEY" БЭЛЭН МӨНГӨ" авах гэсэн товчийг дарна.

ТА УТАСНЫ ДУГААР БОЛОН
ТАН КОДОО ОРУУЛНА УУ.

Тийм _____

Үгүй _____

2. "ТА УТАСНЫ ДУГААР БОЛОН ТАН КОДОО ОРУУЛНА УУ" гэсэн дэлгэц дээр өөрийн гар утасны дугаар болон тан кодоо залгуулан оруулж "Тийм" товчийг дарна.

ТА ДУРЫН 4-Н ОРОНТОЙ
ТОО ОРУУЛНА УУ

3. "ТА ДУРЫН 4-Н ОРОНТОЙ ТОО ОРУУЛНА УУ" гэсэн дэлгэц дээр дурын 4-н оронтой тоог оруулна.

ТА АВАХ МӨНГӨН ДҮНГЭЭ
ОРУУЛНА УУ.
ТАНЫ ОРУУЛАХ ДҮН
БАЙХ ХЭРЭГТЭЙ

Тийм _____

Үгүй _____

4. "ТА АВАХ МӨНГӨН ДҮНГЭЭ ОРУУЛНА УУ. ТАНЫ ОРУУЛАХ ДҮН БҮХЭЛ ТОО БАЙХ ХЭРЭГТЭЙ" гэсэн дэлгэц дээр авах мөнгөн дүнгээ бичиж "Тийм" товчийг дарна.

ТА БАРИМТ АВАХ УУ?

Тийм _____

Үгүй _____

5. Хэрэглэгч Та бэлэн мөнгө авсан баримт авах хүсэлтэй бол "ТА БАРИМТ АВАХ УУ?" дэлгэцний "Тийм" товчийг, үгүй бол "Үгүй" товчийг дарна.

ТА ГҮЙЛГЭЭНИЙ
ХУРААМЖ 100
ТӨГРӨГ ТӨЛӨХ ҮҮ?

Тийм _____


Үгүй _____

6. Хэрэглэгч Та гүйлгээний хураамж 100 төгрөгийг төлснөөр бэлэн мөнгөө хүлээн авна.




ЛАВЛАГАА АВАХ


1. Үлдэгдэл шалгах




1. Лавлах цэсийг сонгоно.



2. Үлдэгдэл шалгах дэд цэсийг сонгоно.
3. ПИН кодоо оруулна.




4. Үлдэгдэл шалгах дансаа сонгоно.




5. Дансны үлдэгдлийн мэдээлэл ирнэ.


2. Сүүлийн гүйлгээ лавлах



1. Лавлах цэсийг сонгоно.



2. Сүүлийн гүйлгээ дэд цэсийг сонгоно.
3. ПИН кодоо оруулна.




4. Сүүлийн гүйлгээний мэдэгдэл ирнэ.


ШИНЭЧЛЭХ

1. ПИН код солих

Энэхүү цэсээр гүйлгээ хийхдээ ашиглах ПИН кодоо солино. ПИН кодыг шинэ хэрэглэгч болсон болон шинээр үүсгүүлсэн тохиолдолд заавал өөрийн ПИН кодоор солих шаардлагатай.



1. Шинэчлэх цэсийг сонгоно.




2. ПИН код солих дэд цэсийг сонгоно.
3. Одоогийн ПИН кодоо оруулна.
4. Шинэ ПИН кодоо оруулна.
5. Шинэ ПИН кодоо давтан оруулна.
6. ПИН код амжилттай солигдсон мэдэгдэл ирнэ.




ПИН код нь 4-н оронтой тоо байна. ПИН код нь хэрэглэгчийн мэдээллээс агуулаагүй байх ба түгээмэл ашиглагддаг ПИН код байж болохгүй. Жишээ нь 1111, 2222 гэх мэт.

2. Үндсэн данс солих

Бэлэн зарлага болон худалдах гүйлгээнд Таны үндсэн шилжүүлэх данснаас мөнгө хасагдана. Харин мөнгөн шилжүүлэг болон бэлэн орлогын гүйлгээнд үндсэн хүлээн авах дансанд орлого орно.




1. Шинэчлэх цэсийг сонгоно.




2. Үндсэн данс солих дэд цэсийг сонгоно.
3. ПИН кодоо оруулна.
4. Үндсэн шилжүүлэх дансаа сонгоно.
5. Үндсэн хүлээн авах дансаа сонгоно.
6. Баталгаажуулах асуулт гарч ирнэ.
7. Үндсэн данс солигдсон мэдэгдэл ирнэ.

3. Меню шинэчлэх

Most Money систем дээр өөрчлөлт, шинэчлэлт хийгдсний дараа 579 дугаараас менюгээ шинэчлэнэ үү гэсэн мессеж ирсэн тохиолдолд дараах зааврын дагуу менюгээ шинэчлэх хэрэгтэй юм.



1. Шинэчлэх цэсийг сонгоно.



2. Меню гэсэн дэд цэсийг сонгоно.
3. Монгол, англи хэлээ сонгоно.
4. “Таны хүсэлтийг хүлээн авлаа. Хариу иртэл түр хүлээнэ үү” гэсэн мессеж ирнэ.
5. “Most Money меню шинэчлэгдлээ” гэсэн хариу ирснээр меню шинэчлэгдэнэ.




Зөвхөн Энгийн менюг
шинэчлэх шаардлагатай.


4. Тохиргоо

Дараах тохиолдлуудад Та тохиргоонуудаа шинэчлэх шаардлагатай:

- Шинээр данс нэмсэн, хассан бол дансаа шинэчлэх
- Шинээр биллер нэмсэн хассан бол биллерийн жагсаалтаа шинэчлэх
- Шинэ цэнэглэгч карт нэмэгдсэн, хасагдсан тохиолдолд цэнэглэгч картын жагсаалтаа шинэчлэх
- Системд шинээр банк, валют, оператор нэмэгдсэн бол тус тусын харгалзах жагсаалтуудаа шинэчлэх
- Хэрэв та бүгдийг нь нэг доор шинэчлэхийг хүсвэл Бүх тохиргоо сонголтоор дээр дурдагдсан бүх тохиргоог нэг дор шинэчлэнэ.



1. Шинэчлэх цэсийг сонгоно.



3. Шинэчлэхийг хүссэн дэд цэсийг сонгоно.



2. Тохиргоо дэд цэсийг сонгоно.



Тохиргоо шинэчлэгдсэн мэдэгдэл мессежээр ирнэ.

Дөрөв. ВЭБЭЭР ГҮЙЛГЭЭ ХИЙХ

Та www.mostmoney.mn хаягаар Most Money үйлчилгээний вэб хуудас руу хандаж “Нэвтрэх” хэсэг дээр өөрийн нууцлалаа оруулан дансаа вэбээр удирдах боломжтой.



Анхаарах зүйлс:

- Анх бүртгүүлэхэд мессэжээр ирсэн Нэвтрэх нэр, Нууц үгээ ашиглан Хэрэглэгчийн вэбэд нэвтэрнэ.
- Нэвтэрсний дараа нууц үг болон ПИН кодыг заавал солих шаардалагатайг анхаарна уу.
- Нэвтэрсний дараа “Заавар” хэсгээс вэбээр хэрхэн гүйлгээ хийх заавартай танилцана уу.

Тав. АСУУЛТ & ХАРИУЛТ

MOST MONEY ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ

1. Most Money үйлчилгээ гэж юу вэ?

Гар утас, вэбээр дамжуулан хүссэн үедээ банкны данснаасаа гүйлгээ хийх боломж бүхий үйлчилгээг Most Money гэнэ. Өөрөөр хэлбэл банкны дансуудаа (карт, харилцах, хугацаатай & хугацаагүй хадгаламж) гар утастайгаа холбуулснаар гар утас болон вэбээр дансаа хүссэн үедээ (24/7) удирдан зарцуулж гүйлгээ хийнэ гэсэн үг юм.

2. Бусад ижил төстэй үйлчилгээнүүдээс юугаараа ялгаатай вэ?

Одоогоор Монголын зах зээл дээр байгаа гар утсан дээр суурилсан санхүү, төлбөр тооцооны үйлчилгээ нь зөвхөн нэг банк, эсвэл нэг операторын хэрэглэгчдэд зориулагдсан үйлчилгээ байдаг бол Most Money нь олон банк, олон оператор, олон бизнесийн байгууллагуудыг өөртөө нэгтгэх боломж бүхий үйлчилгээ юм. Энэ нь эцсийн хэрэглэгч төдийгүй, зах зээлд оролцогч бүхий л этгээдүүдийн зардал мөнгө, цаг хугацааг хэмнэсэн үйлчилгээ юм.

3. Аль банкны харилцагч Most Money үйлчилгээг ашиглах боломжтой вэ?

Одоогоор зөвхөн ХХБ, Төрийн банк болон Капитрон банкны харилцагч Most Money үйлчилгээнд бүртгүүлэх боломжтой. Удахгүй бусад банкууд нэмэгдэнэ.

4. Аль операторын хэрэглэгч Most Money үйлчилгээг ашиглах боломжтой вэ?

Одоогоор зөвхөн Мобикомын хэрэглэгч Most Money үйлчилгээг ашиглах боломжтой. Удахгүй бусад операторууд нэмэгдэнэ.



АЮУЛГҮЙ БАЙДАЛ, НУУЦЛАЛ

5. **Most Money хэрэглэгчийн дансны болон гүйлгээний аюулгүй байдлыг хэрхэн хангаж байгаа вэ?**
Хэрэглэгчийн дансны нууцлалыг нэвтрэх нэр, нууц үг, ПИН код болон ТАН код гэсэн нууцлалуудаар хангана. Хэрэглэгч гүйлгээ хийх бүртээ ПИН кодоо оруулах шаардлагатай. Банк болон операторын системүүдээр хэрэглэгчийн ПИН кодыг тусгай алгоритмаар хөрвүүлж /encrypt хийж/ дамжуулдаг тул хэрэглэгчийн ПИН кодыг өөрөөс нь өөр хэн ч мэдэх боломжгүй юм. Бэлэн зарлага болон худалдах гүйлгээнд ПИН кодны оронд ТАН кодыг ашиглана. Ингэснээр хэрэглэгчийн ПИН кодыг олон нийтийн газар бусдад илчлэгдэхээс хамгаалах юм.
6. **ПИН код гэж юу вэ?**
ПИН код нь таны дансны нууцлалыг хангаж буй 4-н оронтой тоо /2456, 1452 гэх мэт/ юм. ПИН кодыг гүйлгээ хийх бүрт ашиглана. Таныг анх Most Money үйлчилгээний хэрэглэгчээр бүртгүүлэхэд системээс шинэ ПИН код үүсгэж өгөх ба та үүнийг өөрийн ПИН кодоор солих ёстой. Солиогүй тохиолдолд гүйлгээ хийгдэхгүй. ПИН кодыг бусдад мэдэгдэхгүй байхыг анхаарна уу. Most Money үйлчилгээний ПИН код нь гар утасны СИМ картын ПИН кодоос ялгаатай.
7. **Нэвтрэх нэр гэж юу вэ?**
Нэвтрэх нэрийг Most Money үйлчилгээний хэрэглэгчийн вэб болон Андроид, iPhone, интернет меню рүү нэвтрэхэд ашиглана. Та Most Money үйлчилгээний хэрэглэгчээр анх бүртгүүлэхдээ нэвтрэх нэрээ сонгоно.
8. **Нууц үг гэж юу вэ?**
Нууц үгийг Most Money үйлчилгээний хэрэглэгчийн вэб рүү нэвтрэхэд ашиглана. Нууц үг нь үсэг, тоо холилдсон 6-16 тэмдэгтийн урттай байна. Таныг анх бүртгүүлэхэд системээс шинээр нууц үг үүсгэж өгөх ба үүнийг өөрийн нууц үгээр өөрчлөх ёстой. Нууц үгийг бусдад мэдэгдэхгүй байхыг анхаарна уу.

9. ПИН кодоо мартсан бол яах вэ?

Хэрэв та ПИН кодоо мартсан бол Most Money үйлчилгээг үзүүлж буй аль нэг банкны салбар дээр бичиг баримттайгаа очиж шинээр үүсгүүлнэ.

10. ПИН кодоо түгжсэн бол яах вэ?

Хэрэв та ПИН кодоо 3 удаа буруу оруулан түгжсэн тохиолдолд үйлчилгээ авсан банкныхаа лавлах утас руу холбогдож нууц асуулт, хариултандаа хариулан нээлгэх боломжтой. Эсвэл банкны салбар дээр бичиг баримттайгаа биечлэн очиж нээлгэнэ.

11. ПИН кодоо бусдад алдсан бол яах вэ?

Та аль болох хурдан хуучин ПИН кодоо солих эсвэл хэрэглэгчийн вэбээр орж үйлчилгээний эрхээ түр хаах хэрэгтэй. Ингэснээр тухайн хүн таны дансыг захиран зарцуулах боломжгүй болно. Эсвэл Most Money үйлчилгээний 33-57-57 лавлах утсанд хандаж үйлчилгээний эрхээ түр хаалгаж болно.

12. Нууц үгээ түгжсэн бол яах вэ?

Хэрэв та нууц үгээ 3 удаа буруу оруулан түгжсэн тохиолдолд үйлчилгээ авсан банкныхаа лавлах утас руу холбогдож нууц асуулт, хариултандаа хариулан нээлгэх боломжтой. Эсвэл банкны салбар дээр бичиг баримттайгаа биечлэн очиж нээлгэнэ.

13. Нууц үгээ мартсан бол яах вэ?

Хэрэв та нууц үгээ мартсан бол хэрэглэгчийн вэб дээр нууц асуулт, хариултаа оруулан шинээр нууц үгээ дахин үүсгэх боломжтой. Эсвэл банкны салбар дээр иргэний үнэмлэхтэйгээ биечлэн очиж шинээр үүсгүүлнэ.

14. ТАН код гэж юу вэ? Хаана ашигладаг вэ?

ТАН код /нэг удаагийн нууцлал/ нь бэлэн зарлага болон худалдах гүйлгээнд ПИН кодны оронд ашиглагдах 6-н оронтой тоо /458765, 256348 гэх мэт/ юм. ТАН код нь 5 минутын хугацаанд хүчинтэй байх ба ТАН кодыг зөвхөн нэг гүйлгээнд л ашиглана. ТАН кодыг АТМ дээрээс бэлэн зарлага хийх, банкны салбар дээр утасны дугаараар бэлэн зарлага хийх, дэлгүүрийн ПОС-ууд дээр худалдах гүйлгээ хийх гэсэн тохиолдлуудад ашиглана.

15. Гар утсаа алдсан, гэсэн бол яах вэ?

Та гар утсаа алдсан ч Most Money үйлчилгээний ПИН кодоо бусдад мэдэгдээгүй тохиолдолд таны дансны аюулгүй байдал алдагдахгүй. Хэрэв та хүсвэл үйлчилгээний эрхээ түр хаах болон ПИН кодоо солиж болно.

16. Гар утас унтарсан тохиолдолд дансаа удирдах боломжтой юу?

Хэрэв таны гар утас унтарсан тохиолдолд хэрэглэгчийн вэбээр орж гүйлгээ хийж болно. Эсвэл өөр хэрэглэгчийн Андроид, iPhone, интернет меню дээр нэвтрэх нэр, утасны дугаараа оруулан гүйлгээ хийж болно.

ҮНЭ ТАРИФ

17. Үйлчилгээг ашиглахад ямар төлбөр төлөх вэ?

Most Money үйлчилгээг ашиглахад дараах 2 төрлийн төлбөр тооцогдоно.

- Гүйлгээний төлбөр /Үйлчилгээ бүрийн төлбөрийг банкууд тогтоох бөгөөд Та данс байрлаж буй банкныхаа үнийг www.mostmoney.mn/price хаягаар орж харна уу./
- Мессежний зардал /Мөн гүйлгээ хийх бүрт Энгийн менютэй бол мессежний зардал, Интернет, Android, iPhone менютэй бол интернэтийн зардал гарна./

БАНКИН ДЭЭР ХИЙГДЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

Та банк дээр иргэний үнэмлэхтэйгээ очиж дараах үйлчилгээнүүдийг авах боломжтой.

18. ПИН кодны түгжээ гаргах (ПИН кодоо 3-н удаа буруу оруулан түгжсэн тохиолдолд)
19. ПИН кодыг дахин шинээр үүсгэх (ПИН кодоо мартсан тохиолдолд)
20. Нууц үгийн түгжээ гаргах (Нууц үгээ 3-н удаа буруу оруулан түгжсэн тохиолдолд)
21. Нууц үгийг дахин шинээр үүсгэх (Нууц үгээ мартсан тохиолдолд)
22. Данс нэмэх (Шинээр данс нэмэх, эсвэл өөр банкны данс холбуулах тохиолдолд)
23. Дэд хэрэглэгч нэмэх (Дэд хэрэглэгч нэмэх, эсвэл өөр утасны дугаар нэмж холбуулах үед)
24. Өдрийн гүйлгээний лимит өөрчлөх (Өдөрт зарлага хийх лимитээ нэмэх үед)
25. Гүйлгээний тохиргоо хийх (Зарим гүйлгээг хийхгүй гэсэн тохиргоо хийлгэх үед)
26. Гүйлгээ хийх цаг тохируулах (Өдрийн зарим цагт гүйлгээ хийхгүй гэсэн тохиргоо хийлгэх үед. Жишээ нь: ажлын бус цагаар гүйлгээ хийхгүй гэх мэт)
27. Гар утасны дугаар солих (Утасны дугаараа үйлчилгээ авсан банк бүр дээрээ очиж өөрчлүүлэх ёстой.)

ХЭРЭГЛЭГЧИЙН ВЭБЭЭР ХИЙГДЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

Та хэрэглэгчийн вэб дээр дараах үйлчилгээнүүдийг авах боломжтой.

28. Мэдэгдэл авах суваг өөрчлөх
29. Хэл солих
30. Цагийн бүсээ өөрчлөх
31. Гүйлгээний эрхээ түр хаах

Долоо. ТУСЛАМЖ

Та Most Money үйлчилгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл авах, худалдаа үйлчилгээний байгууллагуудын хаяг байршлыг харах, санал сэтгэгдлээ илэрхийлэхийг хүсвэл дараах хаягаар хандана уу.






www.mostmoney.mn



Лавлах утас 33-57-57

Өөрийн данс байрших банкны вэбсайт болон лавлах утас:


Банк	Вэб сайт	Лавлах утас
 ТӨРИЙН ХАДААГАА ХӨГЖИЙН БАНК	www.tdbm.mn	331883, 1977
 КапитронБанк Таны туслах санхүүгийн хамт үзүү	www.capitronbank.mn	328373
 ТӨРИЙН БАНК	www.statebank.mn	1899





Дэлгэрэнгүй мэдээлэл:

 www.mostmoney.mn

 33-57-57

